



**БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
ИНСТИТУТИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2019 оны 01 сарын 10 өдөр

Дугаар A/04

Улаанбаатар хот

**Түрээслэгчийг сонгон шалгаруулах
комисс байгуулах тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай” 53 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, 2017 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 268 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багшийн хөгжлийн ордны 1 давхарт номын худалдаа эрхлэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга	О.Цоморлиг /Захиргаа, аж ахуйн хэлтсийн дарга/
Гишүүн	Х.Зоригтзаяа /Барилга, сантехникийн инженер/
Нарийн бичгийн дарга	Н.Ариунтунгалаг /Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн, захирлын туслах/

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг комисс /О.Цоморлиг/-т даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮРЭНЧИМЭГ